



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

БУГАТ СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: БУА-2023/113/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn БУЛГАН ХОТ 2023 он	Дарга, Тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ Утас:70342580 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас:70342716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn Ахлах аудитор: П.Содном Утас:70342495 Цахим хаяг: Sodnomp@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
- 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
- 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
- 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан.....
- 4.1 Ерөнхий зүйл
- 4.2 Материаллаг байдал
- 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2023.02.06 № 16

танай _____ ны № _____ т

БУГАТ СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Б.МӨНХТУЯА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бугат сумын цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бугат сумын цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөх, асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Тайлант онд сургуулийн өмнөх боловсролыг хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээний хэрэгжилт 94.0 хувь, батлагдсан төсвийн 93.2 хувийг гүйцэтгэлээр зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Улсын төсвөөс 179,327.5, орон нутгийн төсвөөс 45,347.9 мянган төгрөгийн санхүүжилт авч орон нутгийн төсвийн зарцуулаагүй үлдэгдэл 904.8 мянган төгрөгийг төвлөрүүлж, улсын төсвөөс авсан санхүүжилтийн зарцуулагдаагүй 15,243.7 мянган төгрөгийг үлдэгдэлтэй, 2022 онд авлагын эхний үлдэгдэл 934.3 мянган төгрөгөөс 834.8 мянган төгрөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, тайлант онд 666.1 мянган төгрөгийн ХХОАТ-ын өглөг үүсгэсэн байна.

Бугат сумын цэцэрлэгийн 2022 санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

008020018

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>46,419,183.10</u>	<u>69,562,976.79</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	15,243,752.11
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	15,243,752.11
3121	Төгрөг	-	15,243,752.11
31211	Төрийн сангийн харилцах	-	15,243,752.11
33	АВЛАГА	934,286.76	871,312.48
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	934,286.76	871,312.48
35	БАРАА МАТЕРИАЛ	45,484,896.34	53,447,912.20
351	Түүхий эд материал	180,000.00	150,000.00
35130	Эм боох материал	180,000.00	150,000.00
354	Хангамжийн материал	45,304,896.34	53,297,912.20
35410	Бичиг хэргийн материал	121,000.00	1,150,300.00
35420	Аж ахуйн материал	43,669,937.76	46,455,536.96
35460	Хүнсний материал	1,513,958.58	5,692,075.24
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>449,533,037.24</u>	<u>416,129,642.76</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	449,533,037.24	416,129,642.76
392	Биет хөрөнгө	430,557,287.10	397,522,642.76
39201	Барилга, байгууламж, орон сууц	415,456,266.20	415,456,266.20
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	(31,958,174.28)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	19,813,351.00	16,247,100.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(12,104,734.10)	(8,625,673.16)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	7,864,600.00	6,867,800.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(4,426,546.94)	(4,370,026.98)
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,690,000.00	2,690,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(334,833.06)	(383,833.02)
39217	Ном	1,599,184.00	1,599,184.00
393	Биет бус хөрөнгө	18,975,750.14	18,607,000.00
39301	Програм хангамж	1,600,000.00	1,600,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(556,249.86)	(925,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	17,932,000.00	17,932,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>495,952,220.34</u>	<u>485,692,619.55</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>666,071.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	666,071.00
413	Өглөг	-	666,071.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	666,071.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>495,952,220.34</u>	<u>485,026,548.55</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	495,952,220.34	485,026,548.55

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	30,743,762.67	30,743,762.67
51101	Өмч: - төрийн	30,743,762.67	30,743,762.67
512	Хуримтлагдсан үр дүн	464,266,535.91	453,340,864.12
51210	Өмнөх үеийн үр дүн	464,266,535.91	463,166,535.87
51220	Тайлант үеийн үр дүн	-	(9,825,671.75)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	941,921.76	941,921.76
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	495,952,220.34	485,692,619.55

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	191,078,271.61	245,690,929.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	21,015,529.20
120	Нийтлэг татварын бус орлого	-	21,015,529.20
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	21,015,529.20
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		5,833,200.00
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		15,182,329.20
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	191,078,271.61	224,675,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	145,664,200.00	179,327,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	179,327,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	145,664,200.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	180,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	180,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	45,234,071.61	45,347,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	45,234,071.61	45,347,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	183,078,455.93	255,516,600.95
21	УРСГАЛ ЗАРДАЛ	183,078,455.93	255,516,600.95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	169,251,525.97	247,087,699.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	97,679,116.00	117,743,162.40
210101	Үндсэн цалин	56,336,289.00	89,858,314.40
210102	Нэмэгдэл	32,512,130.00	21,830,184.00
210104	Урамшуулал	8,830,697.00	6,054,664.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,855,824.12	14,990,451.27
210201	Тэтгэврийн даатгал	8,324,365.66	10,268,887.35
210202	Тэтгэмжийн даатгал	1,015,816.98	1,200,695.43
210203	ҮОМШӨ-ний даатгал	680,706.72	947,116.29
210204	Ажилгүйдлийн даатгал	161,093.68	227,230.97
210205	Эрүүл мэндийн даатгал	1,673,841.08	2,346,521.23
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,618,214.61	38,208,276.86
210301	Гэрэл, цахилгаан	1,785,334.61	1,245,396.86
210302	Түлш, халаалт	36,762,880.00	36,762,880.00
210303	Цэвэр, бохир ус	70,000.00	200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,751,538.00	-
210401	Бичиг хэрэг	480,500.00	-

210402	Тээвэр, шатахуун	645,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	622,000.00	-
210404	Ном, хэвлэл	54,500.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	987,500.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	-
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
210408	Бараа материал ақталсны зардал	2,962,038.00	-
2105	Нормативт зардал	4,665,055.32	14,390,983.34
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	48,000.00	30,000.00
210502	Хоол, хүнс	4,529,455.32	14,360,983.34
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	87,600.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	600,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	600,000.00	1,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	55,400.00	-
210702	Дотоод албан томилолт	55,400.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	88,500.00	234,591.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	88,500.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	234,591.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,937,877.92	60,520,234.44
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,002,938.00	19,891,590.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	594,000.00	2,492,050.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	6,340,939.92	38,136,594.44
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,826,929.96	8,428,901.64
2132	Бусад урсгал шилжүүлэг	350,000.00	7,524,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	350,000.00	7,524,100.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	13,476,929.96	904,801.64
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,476,929.96	904,801.64
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>7,999,815.68</u>	<u>(9,825,671.75)</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,240,000.48	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	2,240,000.48	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(2,240,000.48)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>5,759,815.20</u>	<u>(9,825,671.75)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>191,078,271.61</u>	<u>224,675,400.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>191,078,271.61</u>	<u>224,675,400.00</u>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	145,664,200.00	179,327,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	179,327,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	145,664,200.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	180,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	180,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	45,234,071.61	45,347,900.00

/Төгрөгөөр/

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	45,234,071.61	45,347,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	191,078,271.61	209,431,647.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	191,078,271.61	209,431,647.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	177,251,341.65	201,002,746.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	97,679,116.00	117,077,091.40
210101	Үндсэн цалин	56,336,289.00	89,192,243.40
210102	Нэмэгдэл	32,512,130.00	21,830,184.00
210104	Урамшуулал	8,830,697.00	6,054,664.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,874,254.04	14,927,476.99
210201	Тэтгэврийн даатгал	8,342,795.58	10,205,913.07
210202	Тэтгэмжийн даатгал	1,015,816.98	1,200,695.43
210203	ҮОМШӨ-ний даатгал	680,706.72	947,116.29
210204	Ажилгүйдлийн даатгал	161,093.68	227,230.97
210205	Эрүүл мэндийн даатгал	1,673,841.08	2,346,521.23
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,634,071.61	38,208,276.86
210301	Гэрэл, цахилгаан	1,785,334.61	1,245,396.86
210302	Түлш, халаалт	42,778,737.00	36,762,880.00
210303	Цэвэр, бохир ус	70,000.00	200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,778,700.00	-
210401	Бичиг хэрэг	500,000.00	-
210402	Тээвэр, шатахуун	645,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	433,500.00	-
210404	Ном, хэвлэл	29,400.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,180,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,990,800.00	-
2105	Нормативт зардал	4,150,600.00	18,539,100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	27,000.00	-
210502	Хоол, хүнс	3,861,000.00	18,539,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	262,600.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	600,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	600,000.00	1,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	55,400.00	-
210702	Дотоод албан томилолт	55,400.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,032,700.00	293,501.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,032,700.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	293,501.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,446,500.00	10,957,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,746,000.00	8,729,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	700,500.00	2,227,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,826,929.96	8,428,901.64
2132	Бусад урсгал шилжүүлэг	350,000.00	7,524,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	350,000.00	7,524,100.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	13,476,929.96	904,801.64
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,476,929.96	904,801.64
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	=	15,243,752.11
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	15,243,752.11
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	15,243,752.11

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	30,743,762.67	941,921.76	40,014,816.51	71,700,500.94
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	30,743,762.67	941,921.76	40,014,816.51	71,700,500.94
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	424,251,719.40	424,251,719.40
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	30,743,762.67	941,921.76	464,266,535.91	495,952,220.34
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	30,743,762.67	941,921.76	464,266,535.91	495,952,220.34
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(1,100,000.04)	(1,100,000.04)
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	30,743,762.67	941,921.76	463,166,535.87	494,852,220.30
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(9,825,671.75)	(9,825,671.75)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	30,743,762.67	941,921.76	453,340,864.12	485,026,548.55

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	224,675,400.00	208526846.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	224,675,400.00	208526846.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	217,151,300.00	201002746.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	127,202,100.00	117077091.40
210101	Үндсэн цалин	101,360,800.00	89192243.40
210102	Нэмэгдэл	21,789,600.00	21830184.00
210104	Урамшуулал	4,051,700.00	6054664.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,939,800.00	14927476.99
210201	Тэтгэврийн даатгал	13,558,800.00	10205913.07
210202	Тэтгэмжийн даатгал	1,584,600.00	1200695.43
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,286,200.00	947116.29
210204	Ажилгүйдлийн даатгал	319,800.00	227230.97
210205	Эрүүл мэндийн даатгал	3,190,400.00	2346521.23
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,113,000.00	38208276.86
210301	Гэрэл, цахилгаан	1,400,000.00	1245396.86
210302	Түлш, халаалт	37,063,000.00	36762880.00
210303	Цэвэр, бохир ус	650,000.00	200000.00
2105	Нормативт зардал	18,539,100.00	18,539,100.00
210502	Хоол, хүнс	18,539,100.00	18,539,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	296,000.00	293,501.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	296,000.00	293,501.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,061,300.00	10,957,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,811,300.00	8,729,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,250,000.00	2,227,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,524,100.00	7,524,100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,524,100.00	7,524,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,524,100.00	7,524,100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	224,675,400.00	223,770,598.36
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	179,327,500.00	179,327,500.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	179,327,500.00	179,327,500.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	45,347,900.00	44,443,098.36
132001	Орон нутгийн төсвөөс	45,347,900.00	44,443,098.36
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		15,243,752.11

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тус байгууллага нь 2022 онд эрхлэгч 1, бүлгийн багш 2, туслах багш 2, тогооч 1, нярав 1, нийт 8 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

Хүүхдийн нийгмийн, сэтгэл зүй, танин мэдэхүйн хөгжлийг дэмжих, боловсрол эзэмшихэд тулгарч буй бэрхшээлийг арилгаж сурах, тэгш боломж бүрдүүлэх, хувь хүний онцлогт нийцүүлэн сургалт, үйл ажиллагааг чанар, үр дүнтэй зохион байгуулах, хамтран суралцах арга барилыг сургалтад нэвтрүүлэх зорилгын хүрээнд дараах зорилтуудыг тавьсан байна.

Зорилт:

- ❖ Сургалтын хөтөлбөр төлөвлөгөөг чанартай, үр дүнтэй хэрэгжүүлэх, хүүхэд нэг бүрийн нийгэм, сэтгэл зүй, эрүүл мэнд, танин мэдэхүйн хөгжилд дэмжлэг үзүүлэх, тэгш сурах боломжийг бүрдүүлэх
- ❖ Явцын үнэлгээ нь дээр тулгуурлан, үр дүнгийн үнэлгээг бодитой үнэн зөв тодорхойлох
- ❖ Цэцэрлэгийн орчны аюулгүй байдлыг ханган, хүүхэд сурч хөгжих таатай орчин бүрдүүлэх
- ❖ Сургуулийн өмнөх боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх 5 настай хүүхэд бүрийг боловсролын үйлчилгээнд тэгш хамруулан сургуульд суралцах бэлтгэлийг хангах.
- ❖ Цэцэрлэгийн хүүхэд хамгааллын бодлого боловсруулж хэрэгжүүлэх мэргэжлийн байгууллагатай хамтарч эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллах.
- ❖ Багш ажилтны хөгжлийг дэмжих уян хатан олон хэлбэрт сургалт үйл ажиллагааг хэрэгжүүлж, багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжил, байгууллагын үйлчилгээний чанарт ахиц гаргах.
- ❖ Байгууллагын багш ажилтан бүр ёс зүй хэм хэмжээ шаардлагыг эрхэмлэн, баг хамт олноороо харилцааны эерэг хандлага, соёл төлөвшүүлэх, санал санаачилгыг дэмжих, манлайлах, үр дүнг тооцох зэрэг зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Бугат сумын цэцэрлэг нь “Боловсролын тухай хууль” “Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль” бусад хууль тогтоомж, тушаал шийдвэр, журам зааврыг мөрдөн ажиллан үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомжид Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж дүгнэж байна.

Тус цэцэрлэгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагын бүтэц орон тоонд дотоод аудит байхгүй бөгөөд дээд шатны төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн хяналт, дотоод аудитын хэлтсээс тус онд төлөвлөгөөт хяналт шалгалт хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бугат сумын цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузуул сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Бугат сумын цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 10259.6 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		15243.8	15243.8
Авлага	934.3	871.3	-63.0
Бараа материал	45,484.9	53,447.9	7,963
Үндсэн хөрөнгө	449,533.0	416,129.6	-33403.4
Нийт хөрөнгө	495,952.2	485,692.6	-10259.6
Өр төлбөр		666.07	666.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	495,952.2	485,026.5	-10925.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	495,952.2	485,692.6	-10259.6

/мянган төгрөгөөр/

Дээрх хүснэгтээс харахад төрийн сангийн харилцах данс нь дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 15,243.8 мянган төгрөг нь улсын төсвийн санхүүжилтээс зарцуулаагүй үлдсэн байна.

Бараа материалын оны эхний үлдэгдэл 45484.9 мянган төгрөг эцсийн үлдэгдэл 53,447.9 мянган төгрөг болж өмнөх оноос мянган төгрөгөөр өссөн байна.

Тайлант онд 45,484.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 29,824.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 15182.3 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүй шилжүүлэн авч орлогоор бүртгэж, 37,044.1 мянган төгрөг бараа материалыг үйл ажиллагаанд зарцуулж, үнэ төлбөргүй шилжүүлсэн болон акталж устгасан материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 466,955.4 сая, эцсийн үлдэгдэл 462,392.4 сая төгрөг болж өмнөх оноос 4,563.1 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр үндсэн хөрөнгө бэлтгээгүй, анхны өртгөө элэгдлээрээ нөхсөн 5833.2 мянган төгрөгийн хөрөнгийг данснаас хасаж үнэ, нэмэгдүүлж, 5833.2 мянган төгрөгөөр орлогод авч, 4503.1 мянган төгрөгийн хөрөнгө акталсан байна.

Өр төлбөр: Тайлант онд шинээр цалингийн 666.1 мянган төгрөгийн өглөг үүсэж аймгийн татварын хэлтэстэй тооцоо нийлж баталгаажуулсан байна.

Авлага: Авлага дансны оны эхний үлдэгдэл 934.3, оны эцэст 871.3 мянган төгрөг болж өмнөх оноос 62.9 мянган төгрөгөөр буурсан байна. Авлагын эцсийн үлдэгдлийн 36.5 мянган төгрөг нь нийгмийн даатгалаас авах авлага, 834,8 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 179327.5, орон нутгийн төсвөөс 42,800.0 мянган төгрөгийн санхүүжилт авахаар тусгаж нийт 222127.5 мянган төгрөгийн зарлагыг төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 179327.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 42800.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 179327.5, орон нутгийн төсвөөс 45347.9 мянган төгрөгийн санхүүжилт авч орон нутгийн төсвийн зарцуулаагүй үлдэгдэл 904.8 мянган төгрөгийг төвлөрүүлж, улсын төсвөөс авсан санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдэл 15243.7 мянган төгрөг харилцах дансны үлдэгдлээр тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 208526.8 мянган төгрөг буюу 93.9 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвөөс цалин 5471.8, НДШ 4430.6, байр ашиглалт 3591.7 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Х201 хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	81605	400,0	348.0	52.0	
2	81807	18539.1	18539.1	0	
3	81816	791.8	791.8	0	
4	81823	400.0	400.0	0	
5	81834	121,135.9	106,839	14296.9	
6	81835	38,060.7	37,166	894.7	
7					

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилт байхгүй

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Бугат сумын Цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын туслах үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор П.Содном гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Бугат сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсөв сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсөв 179327.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 2689.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор төсөв санхүү, байгууллагын үйл ажиллагаандаа мөрдөн ажилласан ч зарим зүйл заалттай холбоотой дараах зөрчил байна.

Үүнд: Хүнсний материалын дансны үлдэгдлийг тооллогын бүртгэлтэй тулган баталгаажуулахад 322 кг махны үлдэгдэлтэй, оны эцэст худалдан авч нөөцөлсөн байна. Өдрийн хэрэглээгээр бодоход 5-6 сар хэрэглэх мах бэлдсэн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно:", 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх;" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Энэ хуулийн хүрээнд цалин 5471.8, НДШ 4430.6, байр ашиглалт 3591.7 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй. Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа. Шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих 145 мэдээллээс хугацаандаа оруулсан 142, хугацаа хоцроосон 3 мэдээлэл байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант онд завсрын аудит хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 758.1 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, шилэн дансны мэдээлэлтэй холбоотой 1 албан шаардлага, санхүүгийн тайлангийн иж

бүрдлийг хангуулах чиглэлээр 1 зөвлөмжийг өгч хэрэгжилтийг 2022 оны 06 дугаар сарын 56 тоот албан бичгээр ирүүлж биелэлтийг тооцсон байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	758.1			
Албан шаардлага	1				
Зөвлөмж	1				
Нийт дүн	3	758.1			

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Бугат сумын хүүхдийн цэцэрлэгийн тайлант оны үйл ажиллагаа, төсвийн гүйцэтгэл, ажил гүйлгээ болон санхүүгийн тайланг тасалбар болгож гаргасан өдрөөс хойших үйл явдлыг шинжилж үзэхэд дараагийн аудитаар анхаарах асуудалгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 5253.2 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 1100.0 сая төгрөгийн алдааг залруулж, 4153.2 мянган төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Үүнд: Бусад үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 2 ширхэг гэрийн өмнөх оны элэгдэл 1100000.04 төгрөгийг зардлаар бүртгээгүй нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын 4.35-д "Элэгдэл нь хөрөнгийн ашиглалтын хугацааны туршид элэгдүүлэх дүнг системтэйгээр хуваарилсан хуваарилалтыг хэлнэ. Тайлангийн үеийн элэгдлийн шимтгэлийг зардал гэж хүлээн зөвшөөрнө." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт 3993.2 мянган төгрөгийн зөрчил² илэрч алдаа зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх 2 албан шаардлага хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

Байхгүй.

5.2 Албан шаардлага

1. Санхүүгийн тайлан дахь авлага дансны ажиллагчидтай холбогдсон авлагын 834833 төгрөгийг үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй нь НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Хүнсний материалын дансны үлдэгдлийг тооллогын бүртгэлтэй тулган баталгаажуулахад 322 кг махны үлдэгдэлтэй, оны эцэст худалдан авч нөөцөлсөн байна. Өдрийн хэрэглээгээр бодоход 5-6 сар хэрэглэх мах бэлдсэн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно:", 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх;" гэсэн заалтыг зөрчсөн байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Туслах аж ахуйтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант хугацаанд нийт 4153230 төгрөгийн худалдан авалт И-баримтаар баталгаажуулаагүй, анхан шатны баримтын бүрдлийг хангаагүй байна.

Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйл 17.3.2-д "бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно;", Сангийн сайдын 2017 оны 347 тушаалын хавсралтад "5 Төлбөрийн баримт НХМаягт төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авалт хийхдээ тухайд бүр нь цахим И-баримтыг хангуулан анхан шатны баримтын бүрдэл хангаж бүртгэл тайланд тусгаж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Бусад үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 2 ширхэг гэрийн өмнөх оны элэгдэл 1100000.04 төгрөгийг зардлаар бүртгээгүй.	1	1100.0	1	1100.0			1	1100.0	0	0		
Тайлант хугацаанд нийт 4153230 төгрөгийн худалдан авалт И-баримтаар баталгаажуулаагүй.											1	4153.2
Дүн	1	1100.0	1	1100.0			1	1100.0			1	4153.2

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Санхүүгийн тайлан дахь авлага дансны ажиллагчидт ай холбогдсон авлагын 834833 төгрөгийг үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуул аагүй.	1	834.8	0	0	1	834.8	0	0 0			0	0
Хүнсний материалы н дансны үлдэгдлийг тооллогын бүртгэлтэй тулган баталгаажуулахад 322 кг махны үлдэгдэлтэй , оны эцэст худалдан авч нөөцөлсөн байна.	1	3158.4	0	0	1	3158.4	0	0	0	0	0	0
Дүн	2	3997.2			2	3997.2	1	0 0	0	0	0	0